# МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН 2021 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

## 1. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Мандал даатгал ХК нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 22.6 тэрбум төгрөгний хураамжийн орлого, 3.2 тэрбум төгрөгний ашигтай ажилласанаар төлөвлөгөөгөө 109% биелэлттэйгээр хаалаа.

Тус оны эхний хагас жилд Мандал даатгал ХК нь салбартаа 20.5% эзэлж байна.

Бид 2-р улиралд хүүхдийн гэнэтийн ослын даатгал Гүүмбий Жүүмбий, аялал зугаалга эхэлж буй цаг үетэй зэрэгцүүлэн Аялал 360 багц даатгалуудыг харилцагчиддаа шинээр хүргэж ажиллаа. Тус даатгалуудтай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бидний веб хуудсанд хандан авах боломжтой.

Гүүмбий Жүүмбий хүүхдийн даатгал: http://mandal.mn/post/68338

Аялал 360 даатгал: http://mandal.mn/post/68961

## 2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 1. Компанийн бүтцийн өөрчлөлт

Компанийн бүтцийн хувьд Маркетинг, Бизнес хөгжлийн газрын бүтэц өөрчлөгдөн Бизнес хөгжил, андеррайтингийн газар болон Маркетингийн газар болж өөрчлөгдөв.

### 2. 2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл

- ТУЗ гишүүд тус оны 4 дүгээр сарын 19-ны хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдсон.
- ТУЗ ердийн гишүүн - Ө. Ганзориг
- ТУЗ ердийн гишүүн - Ш. Гантуяа
- ТУЗ ердийн гишүүн - О. Ганжолоо
- ТУЗ ердийн гишүүн - О. Мөнхжаргал
- ТУЗ ердийн гишүүн - Л. Ганзоригт
- ТУЗ ердийн гишүүн - Б. Жавхлан
- ТУЗ хараат бус гишүүн - Жэймс Бернард Двайер
- ТУЗ хараат бус гишүүн - Ж. Дэлгэрсайхан
- ТУЗ хараат бус гишүүн - Г. Гантулга
- Компанийн гүйцэтгэх захирал Б. Жавхлан.

## 3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

Эхний хагас жилд авсан зээл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байхгүй болно.

## 4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

### 1. Хувьцаа эзэмшигдийн хурлын мэдээлэл

Мандал Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 17:00-19:05 цагийн хооронд компанийн албан ёсны фэйсбүүк

https://www.facebook.com/mandaldaatgal/ хаягаар шууд дамжуулан, цахим хэлбэрээр явагдаж санал хураалт болон асуултыг www.stock.mandal.mn сайтаар хүлээн авав.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хуралд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 624,301,600 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2,083 хувьцаа эзэмшигчдээс 535,797,973 ширхэг хувьцаа эзэмшиж буй 36 хувьцаа эзэмшигч буюу 85.82 хувь нь оролцсон тул Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4-т зааснаар “Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны дийлэнх олонх (гуравны хоёр) оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.” гэж заасны дагуу хурал хүчин төгөлдөр болсон байна.

**Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталсан байна:**

- Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
- Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “**ТУЗ**” гэх) ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
- Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах; болон
- ТУЗ-ийн 2021 үйл ажиллагааны зардлын төсөв батлах.

**Хурлаас гарсан шийдвэр:**

1. “Мандал Даатгал” ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,749,948 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,691,610 ширхэг хувьцааны санал буюу 99,99 хувийн саналаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг батлав.
3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгоход өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 4,808,255,859 ширхэг саналыг дараах байдлаар ТУЗ-ийн нэр дэвшигч гишүүдэд өгсөнөөр батлав. /Кумулятив аргаар санал хураасан/ Үүнд:

| Ердийн гишүүнд нэр дэвшигчид | Кумулятив саналын тоо | Хувь |
|---|---|---|
| Өлзийбаяр овогтой ГАНЗОРИГ | 540,343,473 | 11.21 % |

| | | |
|---|---|---|
| Батсайхан овогтой ЖАВХЛАН | 538,163,417 | 11.17 % |
| Очирпүрэв овогтой ГАНЖОЛОО | 532,033,237 | 11.04 % |
| Шаравпэлжээ овогтой ГАНТУЯА | 532,022,620 | 11.04 % |
| Лувсанжамба овогтой ГАНЗОРИГТ | 531,645,197 | 11.03 % |
| Отгон овогтой МӨНХЖАРГАЛ | 531,643,917 | 11.03 % |

| Хараат бус гишүүнд нэр дэвшигчид | Кумулятив саналын тоо | Хувь |
|---|---|---|
| Жамсрандорж овогтой ДЭЛГЭРСАЙХАН | 537,645,353 | 11.16 % |
| Жэймс Бернард ДВАЙЕР | 532,134,230 | 11.04 % |
| Гарамдорж овогтой ГАНТУЛГА | 531,971,971 | 11.04 % |
| Эрдэнэбат овогтой НАНДИНЗҮРХ | 652,444 | 0.01 % |

4. Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд нэмэлт өөрчлөлт оруулахыг батлав.

5. Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хасахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хасахыг батлав.

6. Компанийн дүрмийн 7.16-р зүйлийг нэмэхэд өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 7.16-р зүйлийг нэмэхийг батлав.

7. Компанийн дүрмийн 13.1.13-р зүйлийг нэмэхэд өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар Компанийн дүрмийн 13.1.13-р зүйлийг нэмэхийг батлав.

8. ТУЗ-ийн 2021 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 535,278,980 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

### 2. 2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй.

2021 оны 04 сарын 01-ны өдрийн байдлаарх нөлөө бүхий хувьцаа эзэмшигч

| **Д/д** | **Нэрс** | **Тоо ширхэг** | **Эзэмшил хувь** |
|---|---|---|---|
| 1 | Голомт Файнэншил Групп ХХК | 255,000,000 | 40,85% |
| 2 | Юу Эм Си Капитал ХХК | 227,928,800 | 36,51% |
| 3 | Олон нийт | 141,372,800 | 22,64% |
| **Дүн** | | **624,301,600** | **100,00 %** |

## 5. ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 оны 2-р улирлын байдлаар 78,276 хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж, нийт 22.6 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллалаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10%-иар өссөн үзүүлэлт бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 143%-ийн биелэлттэй байна.







Хураамжийн орлогын 80 хувийг голлох 5 даатгалын хэлбэр эзэлж байгаа бөгөөд эдгээр 5 бүтээгдэхүүний багц харьцангуй жигд байна.

***Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр***




Иргэдийн даатгал/Байгууллагын даатгалын харьцаа

**50/50**

Цэвэр хураамж/Давхар даатгалын харьцаа

**46/54**

2021 оны 2-р улиралд нийт 5,253 даатгуулагчид 3.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Нийт нөхөн төлбөрийн зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13%-аар өсчээ.







***Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр***




## 6. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт хөрөнгийн хэмжээ 65.5 тэрбум төгрөгт хүрч өссөний 35.7 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ нь компанийн хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, ашигт ажиллагааг дээшлүүлэх суурь болж байна.

2021 оны 2-р улиралд 3.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар цэвэр ашгийн хагас жилийн төлөвлөгөөг 109%-тай биелүүлээд байна.













***Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж***



## Санхүүгийн байдлын тайлан

| *сая төгрөгөөр* | **2,019** | **2,020** | **2021Q2** |
|---|---|---|---|
| *Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө* | 904 | 2,230 | 1,353 |
| *Даатгалын авлага* | 6,253 | 5,257 | |
| *Бусад санхүүгийн хөрөнгө* | 618 | 376 | 343 |
| *Бусад санхүүгийн бус хөрөнгө* | 868 | 561 | 755 |
| *Хөрөнгө оруулалт* | 27,638 | 31,355 | 34,373 |
| *Даатгалын хөрөнгө* | 3,857 | - | - |
| *ДД-ын хойшлогдсон хураамж* | 3,124 | 12,265 | 14,420 |
| *Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг* | 133 | 768 | 753 |
| *Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал* | 600 | 716 | 701 |
| *Үндсэн хөрөнгө /Цэвэр/* | 537 | 1,484 | 1,488 |
| *Биет бус хөрөнгө /Цэвэр/* | 70 | 144 | 71 |
| *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* | - | - | - |
| ***НИЙТ ХӨРӨНГӨ*** | **40,746** | **55,156** | **65,537** |
| *Даатгалын өглөг* | 1,851 | 2,914 | 7,794 |
| *Бусад санхүүгийн өр төлбөр* | - | 19 | 19 |
| *Бусад санхүүгийн бус өр төлбөр* | 738 | 1,776 | 2,269 |
| *Орлогод тооцоогүй хураамжийн нөөц* | 12,834 | 21,371 | 24,615 |
| *Нөхөн төлбөрийн нөөц сан* | 4,594 | 6,422 | 6,568 |
| *Учирсан боловч мэдэгдээгүй ХНС* | 2,326 | 2,490 | 1,393 |
| *Мэдсэн боловч төлөөгүй ХНС* | 819 | 1,640 | 2,682 |
| *Учирч болзошгүй ХНС* | 193 | 1,036 | 1,236 |
| *Тусгай нөөц сан* | 1,256 | 1,256 | 1,256 |
| ***Нийт өр төлбөр*** | **20,017** | **32,502** | **41,265** |
| *Эзэмшигчдийн өмч* | 6,243 | 6,243 | 6,243 |
| *Халаасны хувьцаа* | - | - | - |
| *Нэмж төлөгдсөн капитал* | 4,442 | 4,442 | 4,442 |
| *Хуримтлагдсан ашиг, алдагдал* | 10,115 | 12,116 | 13,401 |
| ***Нийт эздийн өмч*** | **20,729** | **22,654** | **24,272** |
| ***НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ*** | **40,746** | **55,156** | **65,537** |

## Орлогын тайлан

| *сая төгрөгөөр* | **2,019** | **2,020** | **2021Q2** |
|---|---|---|---|
| ***Нийт хураамжийн орлого*** | **28,927** | **33,225** | **22,598** |
| *Даатгалын хураамжийн буцаалт* | (2,211) | (1,600) | (528) |
| *Давхар даатгалын хураамжийн зардал* | (10,842) | (15,221) | (11,969) |
| ***Цэвэр хураамжийн орлого*** | **15,874** | **16,404** | **10,101** |
| *ОТХНС-ийн өөрчлөлт* | (281) | 8,537 | 3,244 |
| *Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт* | (267) | (9,141) | (2,156) |
| ***Орлогод тооцсон хураамж*** | **16,422** | **17,008** | **9,013** |
| *Нийт нөхөн төлбөрийн зардал* | 5,423 | 7,862 | 3,508 |
| *Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр* | 674 | 641 | 232 |
| *Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр* | 384 | 57 | 25 |
| ***Нөхөн төлбөрийн цэвэр зардал*** | **4,364** | **7,164** | **3,251** |
| *Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт* | 1,683 | 985 | (54) |
| *НТНС-ийн ДД-д ногдох хэсгийн өөрчлөлт* | 415 | (635) | 15 |

| | | | |
|---|---|---|---|
| *УБХНС-ийн өөрчлөлт* | (473) | 843 | 200 |
| ***Зардалд тооцсон нөхөн төлбөр*** | **5,990** | **8,357** | **3,412** |
| *Даатгалын гэрээний зардал* | (1,178) | (1,542) | (913) |
| *Давхар даатгалын шимтгэлийн орлого* | 83 | 128 | 80 |
| *Хөрөнгө оруулалтын олз, гарз* | 3,734 | 4,789 | 1,958 |
| ***Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)*** | **13,072** | **12,025** | **6,725** |
| *Хүү, эрхийн шимтгэлийн орлого* | 26 | 30 | 2 |
| *Бусад орлого* | 51 | 345 | 156 |
| *Ерөнхий ба удирдлагын зардал* | (5,611) | (6,601) | (3,109) |
| *Борлуулалт, маркетингийн зардал* | (1,014) | (940) | (321) |
| *Санхүүгийн зардал* | | (255) | (55) |
| *Бусад зардал* | (3) | (418) | (12) |
| *Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)* | 15 | 825 | 138 |
| *Биет болон биет бус хөрөнгө данснаас хассан олз (гарз)* | - | - | - |
| ***Татварын өмнөх ашиг (алдагдал)*** | **6,536** | **5,012** | **3,526** |
| *Татварын зардал* | (665) | (478) | (368) |
| ***ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)*** | **5,871** | **4,534** | **3,158** |

## 7. ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны 2-р улиралд Мандал даатгал ХК нь 2020 оны цэвэр ашгаасаа 1.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан. Нийт 2.2 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.




| Өдрийн дундаж арилжааны дүн | EPS харьцаа | P/E харьцаа |
|---|---|---|
| **18 сая** | **8.6** | **8.5** |

/2021.1.1-2021.6.30/

/2020.7.1-2021.6.30 Trailing 12 Months/